



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ²¹ он ¹¹ дугаар
сарын ²³-ны өдөр

Дугаар ... ^{ХТ/2830}

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх иргэдийн сурч боловсрох эрхийг хангах, хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ⁸ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

ИРГЭДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙГ ХАНГАХ, ХИЧЭЭЛ, СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ НӨХӨХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Дэлхий нийт урьд өмнө тулгарч байгаагүй хүнд сорилттой өнгөрсөн хоёр жилийн хугацаанд нүүр тулж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотойгоор хүн төрөлхтөн амьдралын шинэ хэв маягт шилжлээ. Цар тахалтай тэмцэх, хүн ам, эрүүл мэнд, эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөг бууруулах, эрсдэл багатай даван туулахын тулд улс орон бүр хүчин чармайлт гаргаж байна.

Монгол Улсын Засгийн газар ч 2020 оны 1 дүгээр сараас өнөөг хүртэл хугацаанд коронавируст халдвараас сэргийлэх, эрсдэлийг бууруулахад анхаарал хандуулж, эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөний хүрээнд цар тахлаас улбаалсан эдийн засаг, нийгмийн хүндрэлийг хамтын хүчээр даван туулахыг хичээн ажиллаж байна.

Коронавируст халдварын цар тахал улс орны нийгэм, эдийн засгийн олон салбарт хүчтэй нөлөө үзүүлсний дотор боловсролын салбарт хамгийн ихээр нөлөөлж, иргэдийн сурч боловсрох эрхэд тооцож баршгүй хор уршгийг учрууллаа.

Цар тахлын улмаас сургууль, боловсролын байгууллага хаагдсанаар дэлхийн 190 орны ойролцоогоор 1.6 тэрбум хүүхэд буюу сургуулийн насны нийт хүүхдийн 90.0 хувь нь танхимаар суралцах боломжгүй болсныг ЮНЕСКО энэ оны 5 дугаар сард мэдээлсэн (ЮНЕСКО, 2021). Өнөөдрийн байдлаар дэлхийн 9 орны 38.2 сая суралцагч буюу нийт суралцагчдын 2.4 хувь¹ нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй хэвээр байна (ЮНЕСКО, 2021). Энэхүү тоон үзүүлэлтээс үзэхэд иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ тэдний сурч боловсрох эрхийг хангах амаргүй сорилт дэлхийн улс орнуудын өмнө тулгарч байна.

Цар тахлын үед бүх шатны сургалтын байгууллагыг хааснаар хичээл, сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй, тэгш хүртээмжтэйгээр үргэлжлүүлэн хүргэхийн тулд улс орнууд орон зай, байршлаас үл хамаарч технологийн дэвшлийг ашиглан хичээл, сургалтыг зайн, цахим хэлбэрээр зохион байгуулах нь хамгийн оновчтой хувилбар гэж үзсэн. Хэдий тийм боловч дэлхийн улс орнууд танхимын сургалтаас зайн, цахим сургалтад шилжихэд бэлэн байгаагүй гэдгийг ЮНЕСКО, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас хийсэн олон судалгааны үр дүн харуулсан.

Танхимын сургалт түүхэнд байгаагүй урт хугацаагаар хаагдаж, зайн, цахим хэлбэрт шилжсэн энэхүү үзэгдлийг ЮНЕСКО дан ганц хичээл, сурлагын хоцрогдол бус, айдас, түгшүүр, сэтгэл санааны хямрал давхацсан “Нэгэн үеийн сүйрэл” хэмээн 2021 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан Боловсролын сайд нарын өндөр хэмжээний уулзалтын үеэр тодорхойлсон².

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ерөнхий боловсролын сургуулийн насны иргэдийн сурч боловсрох эрхийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар

¹ <https://en.unesco.org/covid19/educationresponse#schoolclosures>

² <https://en.unesco.org/news/100-million-more-children-under-minimum-reading-proficiency-level-due-covid-19-unesco-convenes>

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдварын цар тахлаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор манай улс бүх шатны сургалтын байгууллагын танхимын сургалтыг 2020 оны 1 дүгээр сараас зогсоож, хичээл, сургалтыг хоёр жилийн хугацаанд зайн, цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд 2019-2020 оны хичээлийн жилд танхимаар хичээллэх нийт өдрийн 47 хувь, 2020-2021 оны хичээлийн жилд 62.5-68.0 хувийг тус тус зайн, цахим хэлбэрээр гэр бүлийн орчинд суралцан өнгөрүүлсэн байна.

Үүсээд байгаа шинэ нөхцөлд хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, тэгш хүртээмжтэй хүргэхэд Засгийн газраас онцгойлон анхаарч, цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах талаар “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг төр, төрийн бус болон аж ахуйн нэгж, олон улсын хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг хангаж байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд уламжлалт танхимын сургалтад ашиглаж ирсэн сургалтын арга зүйг хүүхдийн сонирхолд нийцүүлэн зураг дүрсээр баяжуулж, хүүхдийн оролцоог хангасан дасгал ажлуудыг нэгтгэн “сурагч” төвтэй сургалтын жишиг контент, теле хичээл боловсруулахад Засгийн газар бодлого, үйл ажиллагаагаа чиглүүллээ.

Танхимын сургалт зайн, цахим хэлбэрт шилжсэн хугацаанд боловсрол, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим баримтлан 5756 теле хичээл, 104 интерактив хичээл, 2775 цахим хичээл, 50 цахим контент, радио болон аудио 30 хичээлийг тус тус бэлтгэн, тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор дохионы хэл, тува, казах хэлний орчуулгатайгаар телевиз, радиогоор дамжуулан хүргэх ажлыг Монголын телевизүүдийн холбоо, хувийн хэвшил болон олон улсын байгууллага (Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан)-тай хамтран зохион байгууллаа. Мөн теле хичээлүүдийг онлайн хэлбэрээр www.econtent.edu.mn сайтад байршуулснаар сурагчдыг хүссэн үедээ хичээлээ нөхөж болон давтан үзэх боломжоор хангасан.

Теле хичээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас үүрэн холбооны оператор компаниудтай хамтран www.econtent.edu.mn вэб сайтад байршуулсан теле хичээл болон төгсөх ангийн сурагчдад зориулан www.help.eec.mn, www.eyesh.eec.mn сайт руу үнэ төлбөргүйгээр нэвтрэх боломжийг бүрдүүлсэн нь хүүхдүүдэд бодит дэмжлэг болсон.

Цар тахлын үед төгсөх ангийн сурагчдын хичээл, сургалтад тусгайлан анхаарч, тэдэнд зориулсан онлайн сургалтын талбарыг үүсгэн цахим хичээлийг улсын хэмжээнд X-XII ангид хичээл зааж байгаа шилдэг 602 багш удирдаж, хот, хөдөөгийн сургуулийн ахлах ангийн 30.1 мянган сурагч онлайн хичээлд хамрагдсан. Энэхүү арга хэмжээ нь хөдөөгийн сургуульд сурч байгаа хүүхдэд өөрийн сургуулийн багшийн хичээлээс гадна бусад аймаг, нийслэлийн сургуулийн шилдэг багшийн хичээлд хамрагдах, бусдаас суралцах, хамтран хөгжих боломж олгоход чиглэсэн.

Түүнчлэн сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг тэгш, хүртээмжтэй хангах үүднээс тэдний онцлог, ялгаатай

хэрэгцээнд нийцүүлэн сурах үйл явц, сургалтын материалд тохируулга хийх, видео, аудио болон подкаст хэлбэрээр цахим хичээлийн агуулгыг хүргэх, дасгал ажлын дэвтэр боловсруулах, ганцаарчилсан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай сургалтын хэрэгсэл, төхөөрөмж нийлүүлэх чиглэлээр олон улсын хөгжлийн түнш байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Харааны бэрхшээлтэй хүүхдийн суралцах үйлийг дэмжих, унших чадварыг хөнгөвчлөх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын техникийн дэмжлэгтэй “Цахим ном уншигч-DAISY-E-PUB” төхөөрөмжийг багш, сурагчдад түгээж, сургалтад ашигласан нь зайн сургалтыг дэмжсэн томоохон арга хэмжээ болсон;
- Монгол брайл бичгийг дэмждэг Даксберри программ /брайл бичгийг кирилд, кирил бичгийг брайлд хөрвүүлдэг/, компьютерын монгол цахим брайл гар /брайлаар бичихэд компьютерт кирилээр бичигддэг/ зэргийг ерөнхий боловсролын зарим тусгай сургуульд нийлүүлсэн нь багш, суралцагчийн хамтын ажиллагаа, хичээлийн хэрэглэгдэхүүнийг хүртээмжтэй байдлаар бэлтгэхэд бодит дэмжлэг болж байна.

Мөн “Дэлхийн зөн” олон улсын байгууллага, Мобиком компанитай хамтран үзүүлэнгээр ашиглаж байсан гар утаснуудад теле хичээл суулгаж, тэдгээрийг алслагдсан сумдын интернэтгүй, эсвэл интернэтэд холбогдох төхөөрөмжгүй сургуулийн хүүхдүүдэд хүргүүлэх арга хэмжээ авсан нь үр дүнгээ өгсөн.

Теле хичээлээс гадна сургуулиуд Google Drive, Google Form, Zoom, Moodle зэрэг программуудыг ашиглан цахим анги үүсгэн хичээл, сургалтаа зохион байгуулж, теле хичээлтэй холбоотой тайлбар, давтлага өгөх, сурагчдаас шалгалт, сорил авах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, шинэ шинэ туршлагауд хуримтлуулж чадсан³.

Зайн, цахим сургалтад шилжсэн цаг үед тэгш, хүртээмжтэй боловсролын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэхэд багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг дэмжихэд бүх талын оролцоо, дэмжлэг чухал байсан.

Теле хичээл хүртээмж сайтай хэдий ч эргэх холбоо сул талтай байгаад анхаарч багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг дэмжсэн эргэх холбоог сайжруулах зорилгоор салбарын яамнаас багш нарт зориулсан зөвлөмж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад “Гэр бүлд суурилсан хөгжлийн дэмжлэг үзүүлэх зөвлөмж”-ийг тус тус боловсруулан хүргүүлж ажиллалаа.

Хичээл, сургалт зайн, цахим хэлбэрт шилжсэн цаг хугацаанд эцэг, эх, асран хамгаалагчид гэр бүлийн орчинд хүүхдээ суралцахад нь туслах үндсэн үүргийг гүйцэтгэж, урьд өмнөхөөсөө илүүтэйгээр сурах үйлд нь анхаарч, дэмжлэг үзүүлж ажилласан. Түүнчлэн зарим эцэг, эх, асран хамгаалагчдаас бага ангийн хүүхдийн хувьд анхаарал төвлөрөх, бие даан ажиллах чадвар хангалттай төлөвшөөгүй учраас хүүхдүүд гэрийн орчинд тогтож хичээлээ хийхэд хүндрэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн хөгжлийн түвшин ялгаатай учир түүнийг теле хичээлээр шийдэх гэж оролдох нь тохиромжгүй байгаа талаар санал, шүүмжлэл ирүүлснийг бид анхаарч ажиллаж байна.

³ Онцгой байдлын үеийн теле хичээлийн үр дүн, тохиромжтой байдал, судалгааны тайлан, Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн Сан, IRIM, 2020 он

Хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан хэдий ч эрчим хүчний хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хүртээмжгүй байдал болон бусад шалтгаанаар алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн 178.5 мянган сургуулийн хүүхэд теле болон цахим сургалтад хамрагдах боломжгүй байдалд хүрсэн. Эдгээр хүүхдэд хүрч ажиллах чиглэл баримтлан сургуулийн удирдах ажилтан, багш нар гэрээр нь зочилж, хичээлийн явц, гүйцэтгэлтэй танилцах, дасгал ажлын хэвлэмэл ном, гарын авлага тараах зэрэг нэмэлт зохион байгуулалтыг хийж ажилласан сайн туршлага хот, хөдөөгийн олон сургуульд байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ; Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ; Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж тус тус заасны дагуу үндэсний хэмжээнд цахим сургалтын платформ бий болгож, түүгээр дамжуулан бүх нийтэд зориулсан цахим контент боловсруулах, сургалтад ашиглах зорилгоор MEDLE.mn платформуыг 2021 оны 6 дугаар сараас эхлэн хөгжүүлж байна.

MEDLE.mn платформ нь Монгол Улсын өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч байгаа шилдэг багш нарын бэлтгэсэн цахим хичээлийг сурагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран үзэх боломжийг олгох, цахим контентын нэгдсэн сан бүрдүүлэх зорилго бүхий цахим сургалтын цогц систем юм. Уг платформ нь сурагчийн сурлагын хоцрогдлыг нөхөхөд дэмжлэг үзүүлэх, боловсролыг тэгш хүртээмжтэй болгох, илүү хурдацтай, чанартай байх шийдлүүдийг нэг дор агуулж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар энэ платформд 1.0 сая гаруй иргэн хандсан статистик гарсан байна.

Цахим контент бэлтгэх, цахим хичээлийн санг бүрдүүлэх, баяжуулах, сургалтад мэдээллийн технологийг бүрэн ашиглах, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын бэлэн байдлыг хангах зорилгоор улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймаг, нийслэлийн боловсролын газар, ерөнхий боловсролын 45 сургуульд цахим контент бүтээх бичил студи байгуулах ажлыг эхлүүлээд байна.

КОВИД-19 цар тахал нь бүхэл бүтэн нэг үеийн хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд санаа зовних том хэмжээний асуудлыг үүсгэж байгаа бөгөөд сэтгэлийн түгшүүр, сэтгэл гутрал, амиа егүүтгэх зэрэг асуудлаас сэргийлэх сургуульд суурилсан үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө оруулалт нь 80 жилийн хугацаанд 1 ам.доллар тутамд 21.5 ам.долларын өгөөж өгдөг гэж “Дэлхийн хүүхдийн аж байдал-2021” тайланд дурджээ. Мөн хүүхэд, өсвөр үеийнхний ихэнх нь сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлаа ганцаараа бие даан шийдэхээс илүү бусадтай сэтгэл санаагаа хуваалцаж, дэмжлэг авах замаар шийдвэрлэх нь зүйтэй талаар “Өөрчлөгдөж буй хүүхэд нас” хэмээх тайланд ч дурдсан байна (НҮБ-ын Хүүхдийн сан, Галлуп судалгааны байгууллага, 2021). Иймээс улс орнууд хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд анхаарч, хамгаалах, дэмжих, хариу арга хэмжээ авахыг уриалсан байна.

Дээр дурдсан асуудал манай орны хүүхэд, өсвөр үеийнхний тулгамдсан асуудлын нэг болохыг судалгааны үр дүн харуулж байна. Тухайлбал, Боловсрол,

шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2020 онд хийсэн “Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгаа”-аар сурагчдын 76.8 хувь нь сэтгэл зовнилтой байна⁴, 6-13 насны хүүхдүүд стресс бухимдал хэвийн үзүүлэлтээс өндөр бөгөөд сурагчдын дийлэнх нь КОВИД-19 цар тахлаас, сурлагаар хоцрогдохоос айж байгаа тул айдсыг багасгахад дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай байна⁵ гэжээ.

Дээр дурдсан судалгааны үр дүнд үндэслэн сурлагын хоцрогдол нөхөх, арилгах асуудлын нэгэн адилаар сурагчдад нийгэм-сэтгэл зүйн эерэг орчин бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуульд боловсролын сэтгэл зүйчийг ажиллуулж байна. Өнөөдрийн байдлаар 121 сургууль (үүнээс төрийн өмчийн 99 сургууль)-д нийт 124 (үүнээс төрийн өмчийн сургуульд 102) мэргэшсэн сэтгэл зүйч ажиллаж байна.

Хоёр. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах талаар баримталж байгаа бодлого, арга хэмжээний талаар

Танхимын хичээл, сургалтын үйл ажиллагаа түүхэнд байхгүй урт хугацаагаар хаагдаж, зайн, цахим хэлбэрт шилжсэний улмаас нийт сурагчдын гуравны хоёр нь буюу 1.0 тэрбум сурагч сурлагын хоцрогдолтой, бага ангийн 100 сая хүүхэд уншиж чадахгүй байгааг 2021 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан Боловсролын сайд нарын өндөр хэмжээний уулзалтын үеэр ЮНЕСКО мэдээлсэн байдаг. Мөн Дэлхийн банк, ЮНЕСКО-той хамтран хийсэн судалгаагаар⁶ III ангийн сурагчдын хувьд нэг жилийн хичээлтэй тэнцэхүйц хичээл, сурлагын хоцрогдол үүссэн бөгөөд дэмжих хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд 50 хувийн алдагдлыг нөхөх боломжтой хэмээн тооцсон байна.

Багш, хамт олонтойгоо нүүр тулж харилцдаг танхимын сургалтыг зайн, цахим сургалт бүрэн орлож чадахгүйгээс шалтгаалж сурагчдын тухайн ангид эзэмших ёстой мэдлэг, чадварт тодорхой алдагдал үүссэн болохыг олон улсад хийсэн судалгааны үр дүнгүүд мөн илтгэн харуулж байгаа.

Манай улсын хувьд хоёр жилийн хугацааны хичээл, сургалтын агуулгын алдагдлыг нэг жилд бүрэн арилгах боломжгүй бөгөөд олон улсад тооцож байгаа аргачлалаар тухайн нэг сурагчийн хувьд дор хаяж 1-1.5 жилд судлах агуулгыг бүрэн судалж чадаагүй, сурлагын хоцрогдолд орсон байж болзошгүй гэсэн тооцоог салбарын яамнаас хийсэн.

Теле, цахим хичээлийн үргэлжлэх хугацаанд тавигдах шаардлагаас үүдэн тухайн хичээлийн агуулгыг танхимд судлах хугацааны 20 орчим хувьд багтаан сурагчдад хүргэсэн нь сурлагын хоцрогдолд нөлөөлж байна. Мөн энэ оны 3 дугаар сард багш нараас авсан асуулгаар судалгаанд хамрагдсан багш нарын 92.5 хувь нь сурагчдын сурлагын хоцрогдлыг 40-50 хувьтай гэж үзсэн байна.

⁴ “Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн, тохиромжтой байдал”, судалгааны тайлан, Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан, IRIM, 2020

⁵ “Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх”, судалгааны тайлан, Боловсрол, шинжлэх ухааны яам, Монгол Улсын Их Сургууль, НҮБ-ын Хүүхдийн сан, 2020

⁶ Building Back Better After COVID-19: The Importance of Tracking Learning Inequality, João Pedro Azevedo, Lead Economist, Education Global Practice, World Bank Group and Silvia Montoya, Director, UNESCO Institute for Statistics (UIS) 2021/03/24

Цар тахлын үеийн хөл хорионы улмаас бий болсон сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, энэ оны 9 дүгээр сараас үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү арга хэмжээ (төлөвлөгөө)-г дэлхийн улс орнуудад хичээл, сурлагын хоцрогдлыг нөхөх арга хэмжээнд хэрэглэж байгаа 3R (Reconnection, Recovery, Resilience) буюу эргэн холбох, нөхөх, тогтворжуулах гэсэн 3 шатлалт загварт суурилан 2021-2023 онд хэрэгжүүлэх юм.

Хичээл, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2021-2023 онд нийт 373.0 тэрбум төгрөг шаардагдах тооцоотой байгаа бөгөөд НҮБ-ын Хүүхдийн Сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын Монгол дахь төлөөлөгчийн газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, Японы Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн зэрэг олон улсын байгууллагууд дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс танхим болон танхимын бус хосолсон хэлбэрээр эхлүүлээд гурван сар өнгөрч байна. Халдварын тархалтын түвшнээс хамаарч хичээл, сургалтыг зохион байгуулах хэлбэрийг ялгаатай байхаар зохицуулсан. Тухайлбал, ногоон, шар түвшинд байгаа аймаг, сум, тосгон, багт байршилтай сургуулийн хичээлийг 5 өдөр танхимаар, улбар шар, улаан түвшинд байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэгт байршилтай сургууль 5 хоног танхимаар, 5 хоног зайнаас (5/9 хувилбар) хичээллэж байна.

Улсын хэмжээнд 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар ерөнхий боловсролын нийт сургуулийн 55.7 хувь (469) нь танхимаар, 43.3 хувь (365) нь 5/9 хувилбараар хичээллэж байгаа бол 0.9 хувь (8) нь зайн хэлбэрт шилжсэн байна.

Цар тахлын хорио цээрээс үүдсэн хичээл, сургалтын хоцрогдлын нөхцөл байдлыг хичээл бүрээр тодруулах зорилгоор оношлох үнэлгээг II-XII ангийн суралцагчдын 10 хувийг хамруулан үндэсний хэмжээнд 2021 оны 9 дүгээр сард, сургуульд суурилсан үнэлгээг 2021 оны 10 дугаар сард тус тус зохион байгууллаа.

Үндэсний хэмжээнд 2021 оны 9 дүгээр сард зохион байгуулсан үнэлгээнд II-XII ангийн 62.8 мянган сурагч хамрагдаж, давхардсан тоогоор 64 хичээлийн агуулгаар 296,282 нэгж үнэлгээ судалгаа хийгдсэн. Энэхүү үнэлгээгээр сурагчдын гүйцэтгэл үндэсний хэмжээнд 2019 онд зохион байгуулсан чанарын үнэлгээний гүйцэтгэлтэй харьцуулахад хичээл бүрд буурсан урьдчилсан үр дүн гараад байна.

Тухайлбал, математикийн хичээлийн оношлох үнэлгээний дүн 2019 оны чанарын үнэлгээний дүнгээс бага ангид 15.1 хувь, дунд ангид 1.6 хувиар тус тус буурсан байна. Мөн II ангийн суралцагчдын унших, бичих чадвар 70.1 хувьтай үнэлэгдэж байгаа нь тэдний 30 хувьд унших, бичих чадварыг нөхөн олгох хэрэгцээ үүссэн, энэ хэмжээгээр багшид ачаалал нэмэгдэж буйг харуулж байна. Иймд багшийн ачааллыг оновчтой зохицуулах, хоцрогдол нөхөх, арилгах чиглэлээр ахмад багш нартай хамтран ажиллах зэрэг сайн туршлагауд зарим аймагт хэрэгжиж байна.

Танхимын сургалт, үйл ажиллагаа төдийгүй спорт, урлагаар хичээллэх, сонирхлын дагуу дугуйлан секцэд хамрагдах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих төлөвлөгөөт арга хэмжээ зэрэг сурагчдын нүүр тулсан харилцаа хязгаарлагдахын

хэрээр тэдэнд бие биеэ хүндэтгэх, шинэ орчин, нээлттэй харилцаанд дасан зохицох, бусдаас суралцах, багаар хамтран ажиллах, асуудлыг хамтран шийдэх зэрэг XXI зууны иргэнд шаардагдах зөөлөн ур чадвар эзэмшүүлэхэд ихээхэн бэрхшээл учирч байна. Энэ бүхнээс дүгнэхэд танхимын сургалтыг тасралтгүй явуулах нь хүүхдийн хөгжил, төлөвшилд нэн чухал хэрэгцээтэй байна.

Хичээлийн хоцрогдлыг нөхөхөд эцэг эх, гэр бүлийнхний оролцоог хангах, нэмэгдүүлэх хүрээнд эцэг эх, гэр бүлийн гишүүд болон I-II ангийн сурагчдад туслах дасгал ажлын дэвтрийг НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран бүтээж, цахим хэлбэрээр байршуулаад байна. Мөн Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр нэгдсэн нэг арга зүйгээр боловсруулсан “Бие даан суралцах ажлын дэвтэр (хуудас)”-ийг бага, дунд, ахлах ангийн сурагчид энэ оны 9 дүгээр сараас эхлэн хичээл, сурлагын хоцрогдлоо нөхөх, арилгахад ашиглаж байна.

Цар тахлын нөхцөл байдалд нийцүүлэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч халдварын нөхцөл байдлаас хамааран танхимын сургалтад бүрэн шилжээгүй байгаа нь сурлагын хоцрогдол арилгах ажлын ахицад нөлөөлж байгаа бөгөөд хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих арга хэмжээ орхигдсон хэвээр байна.

Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах чиглэлээр аймаг, сум, дүүргийн сургуульд сурч байгаагаас үл хамаарч ахлах ангийн хүүхдүүд сонгон судлах хичээлээ улсын шилдэг багш нараас сонгон сургалтын нэгдсэн платформоор судлах боломжийг бүрдүүлэхээр зорьж байна. Энэ хүрээнд е-ахлах сургуулийг хөгжүүлэх, ахлах ангийн сонгон судлах хичээлийн чанарыг сайжруулахад ахиц гарахаас гадна байршлаас үл хамаарч ахлах ангийн хүүхдүүд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдэнэ гэж үзэж байна.

КОВИД-19 цар тахлын улмаас боловсролын салбарт үүссэн хүндрэлийг даван туулах чиглэлээр Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 22 тэрбум төгрөг, Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл (GPE) олон улсын байгууллагаас 14 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкнаас 3 тэрбум төгрөгийн техникийн туслалцааг 2022-2023 онд үзүүлэхээр төлөвлөөд байна. Эдгээр төсөл, хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын цахим шилжилтийг дэмжих, сурагчдын сурлагын хоцрогдлыг арилгах, багшийн мэдээлэл технологийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, цахим сургуулийн жишиг загвар бий болгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Цар тахлын үед зохион байгуулж байгаа зайн, цахим сургалт нь технологийн дэвшлийг боловсролын салбарт ашиглах шинэ боломж, хэлбэр байгааг илтгэн харуулсан төдийгүй үүссэн нөхцөл байдлыг үр дүнтэй даван туулсан туршлага, сургамж болж, цаашид илүү нээлттэй, тэгш хамруулсан, уян хатан боловсролын тогтолцоог бий болгох урт хугацааны зорилтын үндэс суурь болно гэж үзэж байна.

Цар тахлаас үүдсэн хугацааны болон агуулгын хоцрогдол, нэн ялангуяа бага, дунд ангийн тухайд зөвхөн танхимаар хичээллэж, багш-сурагч хоёул өдөр бүр нүүр туулан харилцаж байж нөхөх, арилгах нь хамгийн зөв шийдэл болохыг өнөөгийн бодит байдал бидэнд харуулж байна. Иймээс танхимаар хичээллэх боломжийг цаашид улам бүр нэмэгдүүлэхэд Засгийн газраас онцгой анхаарал хандуулах болно.

Дэлхий нийтээр сургалтын агуулга, арга зүй, орчин, суралцах хэв маягт огцом өөрчлөлтүүд явагдаж, суралцах боломж улам бүр хил хязгааргүй болж байна. Иймээс цаг үеийн нөхцөл шаардлага, суралцах боломжид гарч байгаа өөрчлөлтөд нийцүүлэн боловсролын үйлчилгээний гадна хэнийг ч орхигдуулахгүй тэгш хамруулан сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсролыг иргэдэд эзэмшүүлэх, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх, тэгш бус байдлыг арилгах зэрэг асуудал нь манай орны боловсролын цаашдын зорилт болж байна. Энэхүү зорилтыг хангахын төлөө Монгол Улсын Засгийн газар тууштай ажиллах болно.

-----oOo-----